


БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЭНХБАЯР

2024 оны ... дугаар сарын ... өдөр

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХЭРЭГСЭЛ
АЖЛЫН ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барааны нэр:	Зуны ажлын хүрэм
Тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none">✓ Тендерт оролцогч нь тендерийн материал хүлээн авах хугацаанд техникийн тодорхойлолтод дурдсан бараанаас загвар ирүүлэхгүй байж болох ба харин бараа үйлдвэрлэх материалын дээжийг ирүүлнэ.✓ Тендерийн баримт бичигт заасан тооны хувцасны чанар нь захиалагчид ирүүлсэн загварын материалаас чанарын хувьд ялгаагүй байна.✓ Тухайн хувцас хэрэгсэлд орсон материал нь хүний биед харшил үүсгэх, арьс салстыг цочроох үйлчлэлгүй, будгийн тогтвор сайтай зориулалтын хувцасны материал байна.✓ Материал нь мэргэжлийн байгууллагын сертификат, тодорхойлолт (дүгнэлт), шинжилгээний бичиг зэрэг дагалдах баримт бичигтэй байна.✓ Ажлын хувцасны бүх оёдлыг 1 см-т 3-4, дотор холбох, хавсарсан оёдлыг 1см-т 3-4 хатгацтайгаар, сайн чанарын 20/2, 40/2 номерын утсаар оёно. Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийж өгсөн байна.✓ Угаалга цэвэрлэгээний дараа агшиж (агшилт суналт нь анхны хэмжээний 5%-иас ихгүй) сунахгүй буюу өмсгөлийн анхны хэмжээ болон хувцасны өнгө өөрчлөгдөхгүй байна.✓ Ажлын хувцсанд угаалга, арчилгааны шошго, хувцасны хэмжээ, үйлдвэрлэгчийн нэр, бусад шаардлагатай мэдээллийг хувцас тус бүрд оёж тогтоосон байна.✓ Ажлын хувцас нь эрэгтэй, эмэгтэй загвартай байна. Биеийн анатоми хэлбэрт тохирсон байна.✓ Эрэгтэй 48, 50, 52, 54, 56, 58, 60;✓ Эмэгтэй 42, 44, 46, 48, 50, 52, 54 гэсэн хэмжээтэй байх ба том размерыг захиалгаар хэмжээс авч үйлдвэрлэнэ.✓ Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.✓ Захиалагчийн тендерийн бичиг баримтад заасан барааны чанар стандартын үзүүлэлтээс давсан, илүү сайн чанар, үзүүлэлттэй байвал давуу тал болно. <p>Тендерт оролцогч нь гэрээ байгуулагдсан даруй 50 размерын эрэгтэй, эмэгтэй 1, 1 ширхэг загвар ирүүлж үйлдвэрлэх барааг баталгаажуулна. Энэхүү загварыг баталгаажуулсаны үндсэн дээр захиалгыг гүйцэтгэнэ.</p>
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	Хүний биеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будгийн тогтвор сайтай, эдэлгээний

	явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй байна.
Үзүүлэлт, шаардлагууд	Хөдөлгөөн хийх үед гар чөлөөтэй хөдлөх нөхцөлийг хангах үүднээс ажлын хүрэмний ханцуйн мөрний залгаас хэсэгт хөдөлгөөн чөлөөлөгчтэй байна. Ар болон энгэрийн хуваалтанд хавчуурган гэрэл ойлгогчийг оёсон байна.
	Ажлын хүрэмний урд хэсэгт ташуу халаастай байх ба халаас нь цахилгаантай байна. (Ерөнхий зургийн дагуу)
	Ажлын хүрэмний зах цахилгаан татсан тохиолдолд хүзүү барихааргүй чөлөөтэй байна.
	Ажлын хүрэмний ханцуй хэт өргөн биш стандартын дагуу байна. Ханцуй болон хормой 5 см-ээс ихгүй манжетиктай байх бөгөөд хормойн манжетикны ташаан хэсэгтэй резинтэй байна.
	Ажлын хүрэмний цахилгаан бат бөх байх ба угаахад тэсвэртэй материалаар хийгдсэн байна.
	Эмэгтэй хүрэм эмэгтэйчүүдийн анатомийн бүтцэд тохирсон тайлтай байна.
	Хүрэмний хөндийрүүлэгчтэй халааснуудын дээд үзүүрийн ирмэгийг гадагш болохооргүйгээр их биед даруулж оёно
	Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд эвтэйхэн байна
	Байгууллагын таних тэмдэг бүхий лого зүүн энгэрт, албан хаагчийн нэр баруун энгэрт байрлана.
	Ар нурууны хэсэгт байгууллагын нэрийг (ХЯНАЛТ ШАЛГАЛТ) 4-5см өндөртэйгөөр "ТОМ ҮСЭГ"-ээр оёсон байна. (Хувцасны харьцаанд тааруулах)
	Өнгө ба дотор материал нь угаахад агшдаггүй, будаг гардаггүй, оёдол даах чадвартай байна.
Халаас болон бусад ачаалал өгөх хэсэгт бат бөх байлгах үүднээс давхар бөхөлгөө хийсэн байна.	
Материалын холио, өнгө	Зуны ажлын хүрэм– Гадна материал: Саарал өнгөтэй, анти-статик /нано/ даавуу материал байна. Дотор материал: Зөвхөн ар нуруу, цээжний хэсэгт хөлрөхөөс хамгаалан торон (торон дотор нь өмсөж, тайлахад саад болохооргүй, сунахааргүй) дотортой байх бөгөөд баруун энгэрийн дотор талд халаастай байна.
Ерөнхий зураг /Зуны ажлын хүрэм/	
	

Барааны нэр:	Салдаг дотортой куртка
ТАВИГДАХ ШААРДЛАГА	<ul style="list-style-type: none"> ✓ Тендерт оролцогч нь тендерийн материал хүлээн авах хугацаанд техникийн тодорхойлолтод дурдсан бараанаас загвар ирүүлэхгүй байж болох бөгөөд бараа үйлдвэрлэх материалын дээжийг ирүүлнэ.

	<ul style="list-style-type: none"> ✓ Тендерийн баримт бичигт заасан тооны хувцасны чанар нь захиалагчид ирүүлсэн загварын материалаас чанарын хувьд ялгаагүй байна. ✓ Тухайн хувцас хэрэгсэлд орсон материал нь хүний биед харшил үүсгэх, арьс салстыг цочроох үйлчлэлгүй, будгийн тогтвор сайтай зориулалтын гадуур куртканы материал байна. ✓ Материал нь мэргэжлийн байгууллагын сертификат, тодорхойлолт (дүгнэлт), шинжилгээний бичиг зэрэг дагалдах баримт бичигтэй байна. ✓ Ажлын хувцасны бүх оёдлыг 1 см-т 3-4, дотор холбох, хавсарсан оёдлыг 1см-т 3-4 хатгацтайгаар, сайн чанарын 20/2, 40/2 номерын утсаар оёно. Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийж өгсөн байна. ✓ Угаалга цэвэрлэгээний дараа агших агшилт суналт нь анхны хэмжээний 5%-иас ихгүй) сунахгүй буюу өмсгөлийн анхны хэмжээ болон хувцасны өнгө өөрчлөгдөхгүй байна. ✓ Ажлын хувцсанд угаалга, арчилгааны шошго, хувцасны хэмжээ, үйлдвэрлэгчийн нэр, бусад шаардлагатай мэдээллийг хувцас тус бүрд оёж тогтоосон байна. ✓ Ажлын хувцас нь эрэгтэй, эмэгтэй загвартай байна. Биеийн анатоми хэлбэрт тохирсон байна. ✓ Эрэгтэй 48, 50, 52, 54, 56, 58, 60; ✓ Эмэгтэй 42, 44, 46, 48, 50, 52, 54 гэсэн хэмжээтэй байх ба том размерыг захиалгаар хэмжээс авч үйлдвэрлэнэ. ✓ Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна. ✓ Захиалагчийн тендерийн бичиг баримтад заасан барааны чанар стандартын үзүүлэлтээс давсан, илүү сайн чанар, үзүүлэлттэй байвал давуу тал болно. <p>Тендерт оролцогч нь гэрээ байгуулагдсан даруй 50 размерынхаас эрэгтэй, эмэгтэй 1, 1 ширхэг загвар ирүүлж үйлдвэрлэх барааг баталгаажуулна.</p> <p>Энэхүү загварыг баталгаажуулсаны үндсэн дээр захиалгыг гүйцэтгэнэ.</p>
<p>Эрүүл ахуй, аюулгүйн байдал</p>	<p>Хүний биеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будгийн тогтвор сайтай, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй байна.</p>
<p>Үзүүлэлт, шаардлагууд</p>	<p>Ханцуй нь хөдөлгөөн хийх үед гар чөлөөтэй хөдлөх нөхцөлийг хангасан байх бөгөөд ар болон энгэрийн хуваалтанд ерөнхий зургийн дагуу деталь хэсгийг гаргаж оёсон байна.</p> <p>Куртканы урд хэсэгт 4 уртааш халаастай, халаас бүр цахилгаантай байх ба дээд 2 халаас нь хамгаалалт бүхий далд цахилгаантай байна. (Ерөнхий зургийн дагуу)</p> <p>Куртка нь босоо захтай, /салхи борооноос хамгаалсан нимгэн малгайг зах дотор хийж цахилгаандаж болохуйц/ нимгэн малгайтай байна.</p> <p>Куртканы ханцуй хэт өргөн биш стандартын дагуу байна. Ханцуй 5 см-ээс ихгүй манжетиктай байх бөгөөд зангуу бүхий сойлттой байна.</p> <p>Куртканы цахилгаан бат бөх байх ба угаахад тэсвэртэй материалаар хийгдсэн байна.</p> <p>Эмэгтэй куртка эмэгтэйчүүдийн анатомийн бүтцэд тохирсон тайлтай байна.</p> <p>Куртка хавар намар өмсөх зориулалттай байх тул салдаг дотортой байна.</p> <p>Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд эвтэйхэн байна</p> <p>Байгууллагын таних тэмдэг бүхий лого зүүн гар талд, байгууллагын нэр (хяналт шалгалт) зүүн энгэрт, албан хаагчийн нэр баруун энгэрт байрлана.</p>

	<p>Ар нурууны хэсэгт байгууллагын нэрийг (ХЯНАЛТ ШАЛГАЛТ) 4см-5 см өндөртэйгөөр “ТОМ ҮСЭГ”-ээр оёсон байна. (Хувцасны харьцаанд тааруулах)</p> <p>Өнгө ба дотор материал нь угаахад агшдаггүй, будаг гардаггүй, дулаан алдахгүй, оёдол даах чадвартай байна.</p> <p>Халаас болон бусад ачаалал өгөх хэсэгт бат бөх байлгах үүднээс давхар бөхөлгөө хийсэн байна.</p> <p>Куртканы цахилгаан бат бөх байх ба угаахад тэсвэртэй материалаар хийгдсэн байна.</p>
Материалын холио, өнгө	<p>Зуны ажлын хүрэм– Гадна материал: Саарал өнгөтэй, куртканы зориулалттай 100% полистер холиотой материал байна.</p> <p>Дотор материал: Куртканы дотрын зориулалттай торгомсог материал байх бөгөөд баруун энгэрийн дотор талд халаастай байна.</p>
<p>Ерөнхий зураг /Салдаг дотортой куртка/</p>	
	

Барааны нэр:	Хөдөлмөр хамгааллын гутал
Үзүүлэлт, шаардлагууд	<ul style="list-style-type: none"> ✓ Нүүрс устөрөгчид тэсвэртэй. ✓ -17 хэмд хүртэл өмсөх боломжтой 150 хэмийн халуун тусгаарлана. ✓ Улны хамгаалалттай. ✓ 200 жоул даах төмөр хамгаалалттай. ✓ Дээд хэсэг нь усны хамгаалалттай. ✓ Цахилгаан дамжуулдаггүй. ✓ Тусгай зориулалтын ажлын гутал нь хөлд эвтэйхэн, хүйтэнд болон бороо, цас чийгэнд тэсвэртэй, арьс, ширэн материалаар хийгдсэн байна.
Хамгаалалтын гуталны өнгө	Хар өнгөтэй, Нэхий дотортой, эсгий улавчтай байна.

Барааны нэр:	Толгой хамгаалах хэрэгсэл /Каска малгай/
Үзүүлэлт, шаардлагууд	<p>NSKY-3-V/V-Gard Vented Protective Cap/агааржуулагчтай хамгаалалтын малгай</p> <p>Монгол Улсын MNS 5621:2006, Европын холбооны CE EN397:2012 стандартын шаардлага хангасан</p> <p>Гадар материал: AB8, PE</p>

	<p>Дотор материал: PVC, Сүлжмэл даавуу</p> <p>Бүтэц:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Толгой хамгаалах дуулгын их бие ✓ Дуулга тогтоох эрүүвчтэй байна. ✓ Эрүүвчний туузын өргөн 15 мм-ээс багагүй байна. ✓ Бүслэвчийг толгойд тохируулах цагираг. ✓ Тохируулагч нь ихэсгэж, багасгадаг тохируулгатай байна. ✓ Толгойн оройноос хөндийрүүлэх татуурга ✓ Толгойн хөлс шингээгч жийргэвч <p>Хамгаалалт:</p> <ul style="list-style-type: none"> ✓ -30°C ээс + 150°C температурын нөлөөнөөс толгойг хамгаалах чадвартай. ✓ Механик биетийн цохилтоос 50 Дж цохилтын энергитэй, 5 кН-с их хүчийг толгой руу дамжуулахгүй ба 30 Дж энергитэйгээр хатуу биет өндрөөс унахад малгайн дотор тэсвэрлэх чадвартай ✓ Цахилгааны хүчдэлийн 1000В-ийн үйлчлэлд тэсвэртэй ✓ Толгойны оройноос хөндийрүүлэх татуурга 4 ш ба малгайнд 4-ээс 6 цэгээр холбогдоно. ✓ Хамгаалалтын дуулга нь унахгүйгээр толгойн дээр тогтож байх зориулалтын бэхэлгээний системтэй байна. <p>Жин: Хамгаалалтын дуулга толгойд ирэх 300 гр-аас илүүгүй жинтэй байна.</p> <p>Зориулалт: Үйлдвэрийн үйл ажиллагаанд ажиллагсдын толгой хамгаалах зориулалттай</p>
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	Хүний биеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будгийн тогтвор сайтай, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй байна.
Малгайн өнгө, хэрэглээ	Өнгө: Цагаан, Хэрэглээ: Толгой хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдал, зөв угсарсан эсэх, техникийн үзүүлэлт нь хөдөлмөрийн нөхцөлд тохирч буй эсэхийг нарийн шалгаж тогтоосон байх

№	Ажлын хувцасны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж
1.	Зуны ажлын хүрэм	87	ширхэг
2.	Салдаг дотортой куртка	87	ширхэг
3.	Хөдөлмөр хамгааллын гутал	40	ширхэг
4.	Толгой хамгаалах хэрэгсэл (каска)	20	ширхэг

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Б.МӨНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН: ГТХХУБ


Ч.ГАНХУЯГ